



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/19

Хужирт сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус суманд “Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж ӨВАХУСЗДТГ/202301017” барааны нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Жамъянсүрэн- (Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер)

Нарийн бичгийн дарга: Д.Мөнхбат (Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Л.Цэдэв (Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

Б.Бямбасүрэн (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Ш.Сангицмаа-(Иргэний төлөөлөл-зөвшилцсөнөөр)

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулж, нийлүүлэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг танилцуулахыг Үнэлгээний хорооны дарга (Б.Жамъянсүрэн)-д үүрэг болгосугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгийг холбогдох хууль, журмын дагуу архивын нэгж бүрдүүлэн Засаг даргын Тамгын газрын Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Д.Мөнхбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

500001097

D:Alban bichig;Zahiramj 2023